

Ургамлын тосны үйлдвэр байгуулах төслийн товч танилцуулга

Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл	
Төслийн нэр	Ургамлын тосны үйлдвэр
Байршил	Аймгийн төв үйлдвэрлэлийн бүсэд
Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Чанартай эрүүл хүнсээр хүн амын хэрэглээг хангах замаар нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх.
Төслийн явц	Судалгааны шатанд
Үйлдвэрлэх бүтээгдэхүүн	Цэвэр ургамлын тос
Зах зээлийн багтаамж	Хүний жилд хэрэглэх ургамлын тосны хэрэглээний норм 9.1 кг байдаг. Тэгвэл Ховд аймгийн 80217 хүн амд жилдээ нийт 729.9 тн ургамлын тос шаардлагатай. Мөн хүн амын нийт хэрэглээн дээр аж ахуйн нэгжид хэрэглэгдэх нь ойролцоогоор 2.3 тн гэвэл нийт 3.029.9 тн ургамлын тос хэрэглэгдэж байна. Үйлдвэр байгуулагдаад бэлэн бүтээгдэхүүн худалдаанд гарахад нэг литр тосыг 3500 төгрөгөөр худалдаалагддаг гэж үзвэл 10.6тэрбум төгрөгийн жилийн борлуулалтын орлоготой байх зах зээлийн орон зай байна.
Хууль эрх зүйн орчин	Хөрөнгө оруулалтын болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана. Мөн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.4 дахь заалтад тусгагдсан.
Орон нутгийн дэмжлэг	Орон нутгаас үйлдвэрлэлийн бүсэд газар олгож дэмжинэ.
Санхүүжилтийн хэлбэр	Хувийн
Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ	800.000.000
Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ	800.000.000
Үйлдвэрлэлийн хүчин чадал	Жилд 6000.0 тн ургамлын тос үйлдвэрлэх. /Баруун бүсийн аймгуудын зах зээлд нийлүүлэх боломжтой./
Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн	Экологийн цэвэр бүтээгдэхүүнийг орон нутагтаа үйлдвэрлэснээр ажлын байр шинээр бий болж аймгийн ДНБ-д эзлэх аж үйлдвэрийн салбарт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувийн жин нэмэгдэнэ.

Гурилын үйлдвэр байгуулах төслийн товч танилцуулга

Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл	
Төслийн нэр	Гурилын үйлдвэр
Байршил	Аймгийн төв үйлдвэрлэлийн бүсэд
Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн болох гурилын үйлдвэрийг орон нутагт байгуулж хэрэглэгчдэд гурилболон малын тэжээлнийлүүлэх.
Төслийн явц	Ховд аймгийн Булган суманд “ Булган баян буудай” ХХК-ны гурилын үйлдвэр байгуулагдсан боловч сүүлийн 3 жил ажиллаагүй . Аймгийн төвд шинээр байгуулах үйлдвэр судалгааны шатандаа байна.
Үйлдвэрлэх бүтээгдэхүүн	Стандартын гурил, тэжээл
Зах зээлийн багтаамж	Хүний жилд хэрэглэх гурилын хэрэглээний норм 36.5 кг байдаг. Тэгвэл Ховд аймаг 80217 хүн амтай жилийн гурилын хэрэглээ 293,0 тн болж байна. Мөн аймгийн хэмжээнд жилдээ 473,1 тн гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Нийт 766,0 тн гурилын хэрэглээ байна.
Хууль эрх зүйн орчин	Хөрөнгө оруулалтын хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана.
Орон нутгийн дэмжлэг	Орон нутгаас үйлдвэрлэлийн бүсэд газар олгож дэмжинэ.
Санхүүжилтийн хэлбэр	Хувийн
Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ	300.000.000
Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ	300.000.000
Үйлдвэрлэлийн хүчин чадал	Өдөрт 10.0 тн гурил үйлдвэрлэх.
Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн	Үүний үр дүнд Улаанбаатар болон ОХУ-аас нийлүүлэгдэх гурилын хэмжээ багасаж холоос зөөвөрлөх тээврийн зардал багасах Ховд аймгийн болоод баруун аймгуудын гурилын хэрэгцээг хангах юм.

Хаягдал цаас боловсруулах үйлдвэр байгуулах төслийн товч танилцуулга

Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл	
Төслийн нэр	Хаягдал цаас боловсруулах үйлдвэр
Байршил	Аймгийн төв үйлдвэрлэлийн бүсэд
Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Орон нутгийн албан байгууллагуудын хаягдал цаасыг боловсруулж ариун цэврийн цаас үйлдвэрлэх зорилготой. Хаягдал цаас боловсруулах үйлдвэр байгуулснаар баруун бүсийн аймгуудын ариун цэврийн цаасны хэрэглээг орон нутгийн үйлдвэрлэлээр хангах боломжтой.
Төслийн явц	Судалгааны шатанд
Үйлдвэрлэх бүтээгдэхүүн	Ариун цэврийн цаас үйлдвэрлэх
Зах зээлийн багтаамж	Одоогоор “БГЭЭМ”ХХК нь БНХАУ-аас ариун цэврийн цаасыг бэлнээр нь худалдан авч зүсэж худалдаанд гаргаж байна. Ховд аймаг нийт 80217 хүн амтай. Жилдээ 4,8 сая ширхэг ариун цэврийн цаас худалдаалагдаж байна. Хаягдал цаасны нөөц боломжоос шалтгаалан үүний 30 хувийг 1.4 сая ширхэгийг /77000000м/ орон нутгийн үйлдвэрлэлээр хангах боломжтой юм.
Хууль эрх зүйн орчин	Хөрөнгө оруулалтын хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана. Мөн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.15 дахь заалтад тусгагдсан.
Орон нутгийн дэмжлэг	Орон нутгаас үйлдвэрлэлийн бүсэд газар олгож дэмжинэ.
Санхүүжилтийн хэлбэр	Хувийн
Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ	130.000.000
Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ	130,000.000
Үйлдвэрлэлийн хүчин чадал	Хоногт 5500 ш /1 ширхэг нь 55-60 метртэй/ ариун цэврийн цаас үйлдвэрлэх
Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн	Орон нутаг импортоор авдаг бүтээгдэхүүнийхээ тодорхой хувийг дотоодын нөөц бололцоогоо ашиглан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж ажлын байр нэмэгдүүлнэ.

**Хаягдал хуванцар сав боловсруулах үйлдвэр
байгуулах төслийн товч танилцуулга**

Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл	
Төслийн нэр	Хаягдал хуванцар боловсруулах үйлдвэр
Байршил	Аймгийн төв үйлдвэрлэлийн бүсэд
Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Энэхүү үйлдвэрийн түүхий эд, материалд хэрэглэгдэх хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зүй зохистой боловсруулж, импортоор авдаг зарим бүтээгдэхүүнийг орон нутагт үйлдвэрлэхэд оршино.
Төслийн явц	Судалгааны шатанд
Үйлдвэрлэх бүтээгдэхүүн	Хуванцар хаягдлаар бүтээгдэхүүн үйлдвэрлэх
Зах зээлийн багтаамж	2013 оны байдлаар Ховд аймагт үйлдвэрлэн хуванцар саванд савласан цэвэр ус, ундааны хэмжээ статистик мэдээгээр 174.0 мянган литр байна. Үүнд нийт ойролцоогоор 87.0 мянган ширхэг хуванцар сав хэрэглэгдсэн гэж үзвэл мөн энэ хэмжээний хаягдал хуванцар бий болж байна. Мөн Улаанбаатар болон бусад газраас нийлүүлэгдэж байгаа ус, ундаа, пивоны хэмжээ 205.8 тн орчим гэж судалгаагаар харагдаж байна. Жилдээ ойролцоогоор 3800.0 орчим мянган ширхэг хуванцар сав дахин боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх сул зах зээл байна. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр нь үнэ өртөг багатай ногоон байгууламжийг хамгаалах, бэлчээр, тариалангийн талбай хашаалж хамгаалахад хэрэглэх зах зээл нь орон нутагт байгаа юм. Одоогоор аймгийн төвд хуванцар цуглуулж бэлтгэн нийлүүлэх үйл ажиллагааг “ Дэвшилт Эко Орчин” ХХК, иргэн О.Ожуу нар явуулж байгаа хэдий ч боловсруулалт хийхгүй байна.
Хууль эрх зүйн орчин	Хөрөнгө оруулалтын болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана. Мөн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.15 дахь заалтад тусгагдсан.
Орон нутгийн дэмжлэг	Үйлдвэрлэлийн бүсэд газар олгож дэмжинэ.
Санхүүжилтийн хэлбэр	Хувийн
Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ	190000000 төгрөг
Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ	190000000 төгрөг
Үйлдвэрлэлийн хүчин чадал	Жилд 100 тн хуванцар боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх.
Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн	Орон нутаг импортоор авдаг бүтээгдэхүүнийхээ тодорхой хувийг хоёрдогч түүхий эд боловсруулах замаар нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж ажлын байр нэмэгдүүлнэ.

**Цемент үйлдвэрлэх үйлдвэр
байгуулах төслийн товч танилцуулга**

Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл	
Төслийн нэр	Цементийн үйлдвэр
Байршил	Аймгийн төв үйлдвэрлэлийн бүсэд
Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Ховд аймагт угсармал барилгын технологиос цутгамал буюу каркасан барилгын технологид шилжиж, орон сууцны барилгууд олноор баригдах болсон. Барилга угсралтын ажил өсөхийн хэрээр цементийн хэрэглээ нэмэгдэж байна. Энэхүү цементийн хэрэглээг орон нутгийн үйлдвэрлэлээр хангахад төслийн зорилго оршино.
Төслийн явц	Судалгааны шатанд
Үйлдвэрлэх бүтээгдэхүүн	Цемент үйлдвэрлэх
Зах зээлийн багтаамж	Аймгийн хэмжээнд барилга үйлдвэрлэлийн хэрэгцээнд жилд 20.0-25.0 мянган тонн цементийг БНХАУ-аас экспортлон нийлүүлж байна. Цементийн үйлдвэрийг байгуулахад үндсэн түүхий эд болох шохойн чулууг Ховд аймгийн Буянт сумын нутагт орших Шохойтын ордоос, төмрийн хүдрийг Увс аймгийн Наранбулаг сумын нутагт орших Харганатын ордоос, шаварлаг хольцыг Ховд аймгийн Мянгад сумын нутагт орших Цавын шаврын ордоос, гөлтгөнийг Увс аймгийн Сагил сумын баруун цэрдийн ордоос, нүүрсийг Ховд аймгийн цэцэг сумын нутагт орших Хөшөөтийн ордоос авч ашиглах боломжтой. Шохойн чулууг 22 км, шаварлаг хольцыг 50 км, гөлтгөнийг 320 км, төмрийн хүдрийг 180 км, нүүрсийг 205 км-ээс тус тус татах боломжтой
Хууль эрх зүйн орчин	Хөрөнгө оруулалтын болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана.
Орон нутгийн дэмжлэг	Орон нутгаас үйлдвэрлэлийн бүсэд газар олгож дэмжинэ.
Санхүүжилтийн хэлбэр	Төр, хувийн
Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ	Төслийн тооцоолол хийгдээгүй байгаа
Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ	10000000000
Үйлдвэрлэлийн хүчин чадал	Жилд 100000 тн цемент үйлдвэрлэх
Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн	Стандартын шаардлага хангасан цементээр барилгын үйлдвэрлэлийг хангаж энэ төрлийн импортыг бууруулж баруун бүсийн аймгуудын зах зээл рүү бүтээгдэхүүнээ нэвтрүүлэх юм.

**Шахмал түлшний үйлдвэр
байгуулах төслийн товч танилцуулга**

Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл	
Төслийн нэр	Шахмал түлшний үйлдвэр
Байршил	Аймгийн төв үйлдвэрлэлийн бүсэд
Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Ховд аймгийн Жаргалант сум 7147 өрх айлтай. Үүнээс 5336 гэр хороололд амьдарч байна. Эдгээр айл өрхүүдийн түлшний хэрэглээний тодорхой хувийг утаа багатай, түргэн шаталттай, илчтэй шахмал түлшээр хангах нь чухал болоод байна. Одоогийн байдлаар аймгийн төвд гар аргаар өөрсдийн хэрэглээг хангадаг цөөн өрх байгаа хэдий ч үйлдвэрлэлийн хэмжээнд утааны ялгарал багатай бүрэн шаталттай түлш үйлдвэрлэж байгаа аж ахуй нэгж байхгүй байна.
Төслийн явц	Судалгааны шатанд
Үйлдвэрлэх бүтээгдэхүүн	Хаягдал нүүрс ашиглан бүрэн шаталтат шахмал түлш үйлдвэрлэх
Зах зээлийн багтаамж	1 өрх жилдээ 2 куб/м мод 2 тн нүүрс түлнэ гэж үзвэл 10.6 мянган куб/м мод, 10.6 мянган тн нүүрс түлнэ. Энэ хэрэглээний тодорхой хувийг шахмал түлшний үйлдвэрлэлээр хангаж утаа багасгаж эдийн засгийн хэмнэлт бий болгох боломжтой юм
Хууль эрх зүйн орчин	Хөрөнгө оруулалтын болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана. Мөн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.13 дахь заалтад тусгагдсан.
Орон нутгийн дэмжлэг	Орон нутгаас үйлдвэрлэлийн бүсэд газар олгож дэмжинэ.
Санхүүжилтийн хэлбэр	Хувийн
Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ	100,000,000
Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ	100,000,000
Үйлдвэрлэлийн хүчин чадал	Жилд 8,0 мянган тн шахмал түлш үйлдвэрлэх
Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн	Гэр хорооллын айлуудын түлшний хэрэглээний 75 хувийг шахмал түлшээр хангаж утаа багасгаж хаягдал нүүрсийг эдийн засгийн эргэлтэнд оруулах юм.

**Полистрол хавтангийн үйлдвэр
байгуулах төслийн товч танилцуулга**

Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл	
Төслийн нэр	Полистрол хавтангийн үйлдвэр
Байршил	Аймгийн төв үйлдвэрлэлийн бүсэд
Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Барилгын ханынполистрал хавтан үйлдвэрлэж зах зээлд нийлүүлэх. Полистрал хавтан нь барилгын ханыг дурын хэлбэр дүрс гарган нэмэлт материал хэрэглэхгүйгээр өөрчлөх боломжтой байдаг учраас хувийн сууц барих ханын материал үйлдвэрлэхэд төслийн зорилго оршино.
Төслийн явц	Судалгааны шатанд
Үйлдвэрлэх бүтээгдэхүүн	Полистрол хавтан
Зах зээлийн багтаамж	Ховд аймагт жилдээ 400 гаруй айлын орон сууцбусад барилга байгууламж баригдаж байгаа. Одоогийн байдлаар эдгээр барилгуудын хөнгөн блокны хэрэглээний 40 хувийг орон нутгийн үйлдвэрлэлээр хангаж байна.
Хууль эрх зүйн орчин	Төр хувийн хэвшлийн оролцоотойгоор 1000 айлын хувийн орон сууцны байшин баригдахаар тусгагдсан. Мөн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.4 дахь заалтад тусгагдсан.
Орон нутгийн дэмжлэг	Орон нутгаас үйлдвэрлэлийн бүсэд газар олгож дэмжинэ.
Санхүүжилтийн хэлбэр	Хувийн
Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ	150,000,000
Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ	150,000,000
Үйлдвэрлэлийн хүчин чадал	Жилд 150-200 м ³ полистрол хавтан үйлдвэрлэх
Жилийн борлуулалтын тооцоолол	Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ бүгдийг борлуулах зах зээлийн багтаамж байгаа
Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн	500 айлын орон сууцны барилга болон барилга байгууламжид галд тэсвэртэй, хөнгөн бат бөх полистрол хавтанг ашиглах боломжтой болох юм.

**Төмөр эдлэлийн үйлдвэр байгуулах
төслийн товч танилцуулга**

Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл	
Төслийн нэр	Төмөр эдлэлийн үйлдвэр
Байршил	Аймгийн төв үйлдвэрлэлийн бүсэд
Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Гэр хорооллын айл өрхийн хашаа, гаражны хаалга, албан байгууллага хувийн сууцны гадна хайс, хашаа, цонх, хаалганы хамгаалалт, ахуйн болон нам даралтын зуух гэх мэтийн төмөр эдлэл, эдлэхүүний үйлдвэрлэлийг орон нутагт үйлдвэрлэх зорилготой.
Төслийн явц	Судалгааны шатанд
Үйлдвэрлэх бүтээгдэхүүн	Төмөр эдлэл
Зах зээлийн багтаамж	Жаргалант сумын хэмжээнд 16 иргэн төмөр эдлэлийн гагнуур хийцийн үйл ажиллагаа явуулж байна. Гэвч үйлдвэрлэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа газар байхгүй байна. Тиймээс энэ төрлийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ их байна.
Хууль эрх зүйн орчин	Хөрөнгө оруулалтын болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана. Мөн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.4 дахь заалтад тусгагдсан.
Орон нутгийн дэмжлэг	Орон нутгаас үйлдвэрлэлийн бүсэд газар олгож дэмжинэ.
Санхүүжилтийн хэлбэр	Хувийн
Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ	150,000,000
Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ	150,000,000
Үйлдвэрлэлийн хүчин чадал	Жилд 10000 м ² хүртэл төмөр эдлэлүйлдвэрлэх
Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн	Импортын бүтээгдэхүүнийг багасгаж орон нутгийн үйлдвэрлэлээр чанартай, хямд бүтээгдэхүүнээр зах зээлийн хэрэглээг хангана.

**Замаска үйлдвэрлэх үйлдвэр
байгуулах төслийн товч танилцуулга**

Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл	
Төслийн нэр	Замаска үйлдвэрлэх үйлдвэр
Байршил	Аймгийн төв үйлдвэрлэлийн бүсэд
Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Сүүлийн жилүүдэд барилга угсралтын үйлдвэрлэл нэмэгдсэнээс үүдэн замасканы хэрэглээ өссөн. Тиймээс орон нутгийн түүхий эд нөөц боломжийг ашиглаж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх зорилготой.
Төслийн явц	Судалгааны шатанд
Үйлдвэрлэх бүтээгдэхүүн	Дотор болон гадна замаска
Зах зээлийн багтаамж	Ховд аймагт жилдээ ойролцоогоор 2030.0 мянган м ² барилга шинээр болон засвар үйлчилгээ хийлгэж байна. Тэгвэл м ² -д ойролцоогоор 3 кг замаска шаардагддаг гэвэл гадна, дотно нийт 9.1 мянган тн замаскийг Хятад улсаас импортолж 15.9 тэр бум төгрөгийг гадагш нь урсгаж байна.
Хууль эрх зүйн орчин	Хөрөнгө оруулалтын болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана. Мөн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.15 дахь заалтад тусгагдсан.
Орон нутгийн дэмжлэг	Орон нутгаас үйлдвэрлэлийн бүсэд газар олгож дэмжинэ.
Санхүүжилтийн хэлбэр	Хувийн
Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ	150,000,000
Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ	150,000,000
Үйлдвэрлэлийн хүчин чадал	Жилд 10 тн хүртэл замаска үйлдвэрлэх
Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн	Орон нутгийн түүхий эд нөөц боломжийг эдийн засгийн эргэлтэнд оруулж импортын бүтээгдэхүүнийг аймагтаа үйлдвэрлэнэ.

**Пивоны үйлдвэр байгуулах
төслийн товч танилцуулга**

Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл	
Төслийн нэр	Пивоны үйлдвэр
Байршил	Аймгийн төвд
Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Аймгийн худалдааны газрууд Улаанбаатар хотоос дотоодын болон импортын шар пивийг зөөж зах зээлд нийлүүлж байна. Тиймээс холоос халуун хүйтэнд хадгалалтын горим зөрчигдөж хэрэглээний баталгаат хугацаа алдагдан худалдаалагдаж байгаа пивоны хэрэглээг орон нутгийн үйлдвэрлэлээр хангах зорилготой.
Төслийн явц	Судалгааны шатанд
Үйлдвэрлэх бүтээгдэхүүн	Пиво
Зах зээлийн багтаамж	Манай аймагт архи согтууруулах ундааны тусгай зөвшөөрөлтэй 258 аж ахуйн нэгж байдаг бөгөөд үүнээс супермаркет 4, минимаркет 10 хүнсний дэлгүүр 210, нийтийн үйлчилгээтэй зоогийн газар 15, баар12, зочид буудлын дэргэдэх зоогийн газар 6, кафе1 байна.Эдгээрээс ойролцоогоор худалдааны газрууд нь сард 240 л, үйлчилгээний газрууд ньсард 800л пиво худалдан борлуулж түүгээр үйлчилдэг бөгөөд жилд 2880литр пиво худалдаалж, 9600 литр пивиор үйлчилж нийтдээ 12480 литр пиво борлуулагддаг байна.
Хууль эрх зүйн орчин	Хөрөнгө оруулалтын болон Тусгай зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулагдана.
Орон нутгийн дэмжлэг	Орон нутгаас үйлдвэрлэлийн бүсэд газар олгож дэмжинэ.
Санхүүжилтийн хэлбэр	Хувийн
Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ	1,000,000,000
Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ	1,000,000,000
Үйлдвэрлэлийн хүчин чадал	Жилд 60 тн пиво үйлдвэрлэх
Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн	Үйлдвэр байгуулагдсанаар орон нутгийг төсвийн бүрдүүлэлт болон аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл нэмэгдэх сайн талтай. Нөгөө талаар хэрэглэгчид сул агууламжтай, хэрэглээний шаардлага хангасан согтууруулах ундаа хэрэглэж зөв хэрэглээнд суралцах,архи хэтрүүлэн хэрэглэснээр үүдэх гэмт хэрэг багасах талтай.

**Гэрийн модны үйлдвэр
байгуулах төслийн товч танилцуулга**

Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл	
Төслийн нэр	Гэрийн модны үйлдвэр
Байршил	Аймгийн төвд
Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Хүний биед сөрөг нөлөөгүй уламжлалт аргаар үйлдвэрлэсэн гэрийн үйлдвэрлэл түүнийг дагасан ёс заншлыг орон нутагтаа хэвээр хадгалж үлдэх зорилготой.
Төслийн явц	Судалгааны шатанд
Үйлдвэрлэх бүтээгдэхүүн	Бүх төрлийн гэрийн мод
Зах зээлийн багтаамж	Манай аймагт модон эдлэл үйлдвэрлэх 67-н үйлдвэр, цех ажиллаж байна. Гэрийн мод үйлдвэрлэх түүхий эд болох модыг Завхан болон Увс аймгуудаас татаж авч үйлдвэрлэл явуулах боломжтой. Одоогоор орчин цагийн сийлбэртэй болонэрээн гэрийн мод үйлдвэрлэхгүй байна. Гэрийн мод нь энгийн хийцтэй болон цуулбар унь, ханатай, матмал тоонотой, эрээлсэн болон гар сийлбэртэй зэргээрээ өөр өөр үнэтэй бөгөөд хийц сайтай гэрийг дуудлага худалдаагаар борлуулах боломжтой байдаг.
Хууль эрх зүйн орчин	Хөрөнгө оруулалтын болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана.Мөн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.4 дахь заалтад тусгагдсан
Орон нутгийн дэмжлэг	Орон нутгаас үйлдвэрлэлийн бүсэд газар олгож дэмжинэ.
Санхүүжилтийн хэлбэр	Хувийн
Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ	100,000,000
Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ	100,000,000
Үйлдвэрлэлийн хүчин чадал	Жилд 100 хүртэл гэрийн мод үйлдвэрлэх
Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн	Хүний биед сөрөг нөлөөгүй уламжлалт аргаар үйлдвэрлэсэн гэрийн үйлдвэрлэл түүнийг дагасан ёс заншлыг хадгалж үлдэх сонирхол нэмэгдэж байгаа учраас бургас болон нарс модоор бүх төрлийн гэр үйлдвэрлэх үйлдвэр шинээр байгуулж орон нутгийн болон зэргэлдээ аймгуудад болон экспортод гаргана.

**Арьс, ширэн оёдлын үйлдвэр
байгуулах төслийн товч танилцуулга**

Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл	
Төслийн нэр	Арьс, ширэн оёдлын үйлдвэр
Байршил	Аймгийн төвд
Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Бүх төрлийн арьс , ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж орон нутгийг зах зээлийг арьс, ширэн бүтээгдэхүүнээр хангах.
Төслийн явц	Судалгааны шатанд
Үйлдвэрлэх бүтээгдэхүүн	Бүх төрлийн савхин болон арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх.
Зах зээлийн багтаамж	Одоогийн байдлаар аймгийн хэмжээнд боловсруулсан арьс, ширээр гутал, цүнх хийх үйлдвэрлэл эрхэлж буй 18үйлдвэр, цех байна. Гэвч нэхий, савхин хувцас, цүнх гэх мэт бүтээгдэхүүний үйлдвэрлэл одоогоор байхгүй байна.
Хууль эрх зүйн орчин	Хөрөнгө оруулалтын болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана. Мөн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.6 дахь заалтад тусгагдсан.
Орон нутгийн дэмжлэг	Орон нутгаас үйлдвэрлэлийн бүсэд газар олгож дэмжинэ.
Санхүүжилтийн хэлбэр	Хувийн
Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ	100,000,000
Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ	100,000,000
Үйлдвэрлэлийн хүчин чадал	Боловсруулсан арьс ширээр жилд 30,3мян ширхэг хос гутал, 13,6 мян ширхэг савхин дээл үйлдвэрлэнэ
Жилийн борлуулалтын тооцоолол	
Цэвэр ашгийн тооцоолол	
Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн	Ховд аймаг 80217 хүн амтай. Жилд 30,3 мян ширхэг хос гутал үйлдвэрлэснээр нийт хүн амынгутлын 24,2 %-ийг хангахаас гадна хөдөлмөрийн насны хүн ам 60,9 хувийг эзэлдэг гэж үзвэл савхин дээл үйлдвэрлэснээр хөдөлмөрийн насны хүн амын 81,6 %-ийг орон нутгийн үйлдвэрлэлээр хангах юм. Үүнээс гадна аймгийн ДНБ-нд аж үйлдвэрийн салбарт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн өсөх сайн талтай юм.

Чулууны үйлдвэрийн өргөтгөл төслийн товч танилцуулга

Байгууллагын мэдээлэл	
Компанийн тухай	“Буянт стандарт” ХХК нь 2012 онд байгуулагдаж, Эрдэнэбүрэн сумын хавчигийн улаан гэдэг газраас түгээмэл тархацтай байгалийн баялаг болох боржин чулууг түүхий эдээр ашиглан гудамж , талбайн чулуун зам, цонхны тавцан, шалны гишгүүр , чулуугаар урлах урлагын бүтээгдэхүүн үйлдвэрлэж баруун 5 аймагт нийлүүлж байна.
Эзэмшигчийн нэр	Б.Гомбосүрэн
Гүйцэтгэх захирлын нэр	Ж.Цогтчимэг
Үйл ажиллагаа	Байгалын чулуугаар гудамж , талбайн чулуун зам, цонхны тавцан, шалны гишгүүр , гадна пассат, чулуугаар урлах урлагын бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.
Борлуулалт	2013 оны байдлаар жилдээ 758.0 сая төгрөгийн борлуулалт хийж ажиллаж байна.
Зах зээлд эзлэх байр суурь	2012 оноос эхлэн чулуугаар барилгын материал үйлдвэрлэж байна. Тухайлбал: 2014 онд 360м ² чулуун хавтангаар зөвхөн гудамж талбай тохижуулсан. /Ховд аймгийн төв талбай, Ховд зочид буудлын гадна пассат/
Хаяг	Ховд аймаг Жаргалант сум, Бичигт баг үйлдвэрийн район 5-ж тоот
Хөрөнгө оруулалтын төслийн мэдээлэл	
Төслийн нэр	Чулууны үйлдвэрийн өргөтгөл
Байршил	Аймгийн төвд
Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Байгалийн чулуугаар бүхийл төрлийн барилгын материал, урлагын бүтээл үйлдвэрлэж байна. Цаашдаа үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хүчин чадлыг өргөтгөхөд 1,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байна. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг өргөтгөснөөр баруун аймгуудын зах зээлийг бүрэн хангахын зэрэгцээ экспортод бүтээгдэхүүнээ гаргах зорилготой ажиллаж байна.
Төслийн явц	Одоогоор сардаа 15500м ² чулууг засаж зүсэж барилгын материал үйлдвэрлэж байна.
Үйлдвэрлэх бүтээгдэхүүн	Байгалийн чулуугаар барилгын пассат, чулуун шал, тавцан, гадна зам талбай, хөшөө дурсгалын зүйлс үйлдвэрлэж байна .
Захзээлийн багтаамж	Ховд аймагт төдийгүй баруун 5-н аймагт өрсөлдөгч байхгүй. Чулуугаар хийх бүхий л захиалгыг тус үйлдвэр хийх боломжтой. Иймээс үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлж үйлдвэрлэлээ явуулах зах зээл байна..
Хууль эрх зүйн орчин	Хөрөнгө оруулалтын болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана.
Орон нутгийн дэмжлэг	Орон нутгаас үйлдвэрлэлийн бүсэд газар олгож дэмжсэн
Санхүүжилтийн хэлбэр	Хувийн

Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ	1,5 тэр бум төгрөг
Шаардагдаж буй санхүүжилтийн хэмжээ	0,5 тэр бум төгрөг
Үйлдвэрлэлийн хүчин чадал	Хүчин чадлыг нэмэгдүүлж сард 21500 м2 хүртэл чулууг засаж зүсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх
Жилийн борлуулалтын тооцоолол	2015 онд- 91 500 000, 2016 онд -1 141 875 000, 2017 онд- 1 258 917188, 2018 онд -1 387 956 199
Цэвэр ашгийн тооцоолол	2015 онд -159 974 576, 2016 онд-105 342 405, 2017 онд-169 387 038, 2018 онд-261 322 112
Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн	Төсөл хэрэгжүүлснээр Ховд аймгийн болон баруун бүсийн аймгуудын барилгын материалын чулуугаар хийж болох бүх бүтээгдэхүүний хэрэглээг хангаж цаашлаад экспортод гаргах нөхцөлийг бүрдүүлнэ.